

**Жилийн Тайлан
2022**

Агуулга

01	Гүйцэтгэх удирдлагын илгээлт	4
----	------------------------------	---

02	Компанийн тухай	10
	Товч түүх	10
	Алсын хараа	12
	Эрхэм зорилго	12
	Мөрдөх зарчим	13
	Давуу шинж чанар	13

03	2022 оны онцлох үйл явдал	14
----	---------------------------	----

04	Хувьцаа эзэмшигч, бүтэц зохион байгуулалт	20
	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	22
	Төлөөлөн удирдах зөвлөл	24
	Удирдлагын баг	34

05	Гүйцэтгэлийн тайлан	36
	Үйл ажиллагааны орчин	38
	АрдАпп, АрдКидс	40
	Хөрөнгө оруулалт	42
	Хүний нөөц	43
	Эрсдэлийн удирлага	44
	Хууль, хянан нийцүүлэлт	45
	Маркетинг	46

06	Хөрөнгө оруулалтын багц	48
	Банкны кластер	52
	Даатгалын кластер	54
	Хөрөнгө оруулалтын банкны кластер	56
	Крипто	58


07	Аудитлагдсан санхүүгийн тайлан	60
	Удирдлагын мэдэгдэл	62
	Хараат бус аудиторын дүгнэлт	63
	Санхүүгийн байдлын тайлан	64
	Орлогын дэлгэрэнгүй тайлан	65
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	66
	Мөнгөн гүйлгээний тайлан	67
	Үнэлгээ	68
	Хувьцааны арилжаа	69
	Тайлбар толь	70



Гүйцэтгэх удирдлагын илгээлт

Эрхэм хүндэт Ардын хувьцаа эзэмшигч танаа!

Хутагт овогтой Чулууны Ганхуяг



Эрхэм хүндэт Ардын хувьцаа эзэмшигч танаа!

Юуны түрүүнд, тогтсон уламжлал ёсоор, та бүхэнтэйгээ Ардын жилийн тайлангаараа мэндчилж байгаадаа туйлын их баяртай байна. Та бүхний минь ажил үйлс өөдрөг байгаа гэдэгт итгэлтэй байна. Хөрөнгө Оруулагч Үндэстнийг цогцлоох эрхэм зорилготой манай хамт олны хувьд эргэн тойронд болж байгаа үйл явдал, өөрчлөлт, бидний замд учрах хүндрэл бэрхшээлийг үл ажран, өмнө нь гаргасан стратегиа ягштал хэрэгжүүлсээр ирснийг энэ тайлангаараа харуулахыг хичээсэн болно.

2022 он дэлхий нийтийн хувьд гэнэтийн маш хүнд цохилтуудыг авчирсан жил болж өндөрлөлөө. Оросууд ахан дүүсийн харилцаатай хөрш улс руугаа дайран довтолж, цэрэг дайны ажиллагаа явуулснаас улбаалан КОВИД-19-ийн дараах өсөлтийн найдлага тээж байсан олон улсын нөхцөл байдал хүндэрч, барууны улсууд урд хойчид байгаагүй цогц хориг арга хэмжээг Оросын эсрэг авсан нь тогтсон олон улсын нийлүүлэлтийн хэлхээг түйвээж, бараа, бүтээгдэхүүний хомсдолын эрсдэл болон инфляцыг гаарууллаа. Энэ нь Хятадын "ТЭГ КОВИД" бодлоготой хоршиж, дэлхий нийт эдийн засгийн гүн хямралын ирмэг дээр ирэв. Өндөр инфляцыг хазаарлахын тулд төв банкууд мөнгөний бодлогоо чангалсан нь эдийн засгийн өсөлтөд шууд нөлөөлж, хөрөнгийн зах зээл уналтанд орж, улс төр үймж, нийгмийн сэтгэлзүйд муугаар нөлөөлж, ирээдүйг бүрхэг болгож орхив. Үүний хажуугаар "крипто өвөл" гэж бидний нэрлэж заншсан Биткойны ханшны уналт үргэлжилсээр, оны 4 дүгээр улиралд хамгийн доод цэгтээ хүрэв. Энэ нь бусад алткойны хувьд бүр ч хүндээр туссан бөгөөд 2021 оны дундаас эхлээд энэ салбарын хувьд шил шилээ дарсан муу мэдээнд дарлагдаж, байдал даамжирсаар Луна гэх алгоритм дээр тулгуурласан стэйблокойны дампуурал, хамгийн алдартай Celsius гэх крипто зээлийн компанийн мөхөл, FTX гэх хамгийн том биржүүдийн сүйрлээр үргэлжилсэн юм. Энэ бүх үйл явдал зохицуулалтын орчныг улам бүр тодорхойгүй, бүрхэг болгосон бөгөөд төв банк болон зохицуулагчдын зүгээс мөн тодорхойгүй олон мэдэгдэл, алхам хийж ирсэн нь байдлыг улам даамжруулсаар байгаа юм. Гэсэн хэдий ч Биткойны үнэ ханш он гарсаар сэргэсэн бөгөөд эдийн засгийн хувьд ч дэлхий нийт шинэ бодит байдалд дасан зохицож байгаа шинж тэмдэг илрэн, инфляц тогтворжиж, сэргэлтийн хүлээлтийг бий болов.

Өнгөрсөн оны хувьд Монгол Улс Шинэ Сэргэлтийн Бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж эхэлсэн ажлын эрч саарч, бид эдийн засгаа өсгөх биш, хамгаалах тактик руу шилжихээс өөр замгүй болов. Инфляцыг хазаарлаж, ханшны чөлөөт уналтыг зогсоох, экспортоо тасалдуулахгүй байх, нэн тэргүүний импортын бараагаа зогсолтгүй авах, өрийн удирдлагыг хэрэгжүүлэх, валютын нөөцөө хамгаалах, нийгмийн амар амгалан байдлыг хадгалах, эхлүүлсэн төслүүдээ гацаахгүй явуулах зэрэг олон сорилт эрх баригчдын өмнө тулгарав.

Оны дундуур 16 хувьд хүрч байсан инфляц оны сүүлээр тогтворжиж, 12 хувь руу оров. Монголбанк бодлогын хүүгээ сүүлийн 30 жилийн хамгийн доод түвшин болох 6 хувиас нэмсээр 13 хувь болгосон нь эдийн засагт мөнгөний хомсдолыг мэдэгдэхүйц хэмжээнд үүсгэв. Монгол төгрөгийн ханш унасаар түүхэн доод хэмжээндээ хүрсэн нь иргэдийн худалдан авах чадварт шууд нөлөөлж, олон түмний дунд их хэмжээний бухимдлыг төрүүлсэн юм. Нийгмийн сэтгэлзүй тогтворгүй болж, олныг хамарсан жагсаал цуглаан 4 сард эхэлсэн бол 12 сард төрийн авлига, хээл хахуулийн эсрэг ард түмний дургүйцэл дээд цэгтээ хүрч, сүүлийн 15 жилд гарч байгаагүй том эсэргүүцлийн тэмцэл шинэ он гартал үргэлжилсэн юм. 2021 оны халуурлын үеэр Монголд явагдсан криптогоор мөнгө босгох үйл ажиллагааны гор 2021 оны сүүлээс гарч эхэлсэн бөгөөд төсөл танилцуулж, мөнгө босгосон бүх койнууд унаж, анхны үнээсээ доошоо орсноор нийтийн зүгээс зарим нэгийг нь гэмт хэргийн шинжтэй гэж үзэн шалгаж эхэлсэн нь манай хувьд ч мөн муугаар нөлөөлсөөр байна.

Ард Санхүүгийн Нэгдлийн компаниудын хувьд хувьцааны үнэ ханш нь унаж, ёроолдов. AARD 4,880, AIC 929, ADB 129, TNGR 16,900, CNF 90,720, MNP 995 төгрөгийн ханшаар тус тус хаагдсан бол АрдКойн унаж, доод түвшиндээ хүрч, оныг 29.18 төгрөгтэй үдлээ. АрдКойн 12 дугаар сард хамгийн доод түвшиндээ хүрснээ буцаж өсөн, 30 төгрөг болж тогтворжив. Мэдээжийн хэрэг үүнийг уналт гэж харж болно. Гагцхүү, би дүгнэхдээ олон улс болон Монголд бий болсон нөхцөл байдалд хамтын хүчин зүтгэлийн үр дүнд бид энэ хямралыг тун давгүй даван тууллаа, манай бүх хувьцаа тун зөөлөн газардаж, дараачийн эдийн засгийн сэргэлтийн үед тогтвортой өсөлт гаргаж, манай хувьцаа эзэмшигчдэд сайхан өгөөж өгөх боломж бүрдлээ гэж дүгнэж байгаа.

	44 хөрөнгө оруулалт	36 компани	45 тусгай зөвшөөрөл	8 нээлттэй компани
---	-------------------------------	----------------------	-------------------------------	------------------------------

Нэгдлийн дотоод нөхцөл байдал болон орчны төлөв, хандлагад хийсэн дүн шинжилгээний үр дүнд бид оны дундуур бүтцийн өөрчлөлт хийх тухай ТУЗ-дөө танилцуулж, батлуулан Ард Санхүүгийн Нэгдлийн үндсэн хөрөнгө оруулалтуудаа үндсэн 8 хэсэгт хуваан, санхүүгийн 3 кластерыг онцгойлон тусгаарлав. Үүнд, банкны, даатгалын болон хөрөнгө оруулалтын банкны гэх кластер орно. Харин өдөр тутмын үйл ажиллагаанд нь шууд оролцохгүй, цаашид оруулсан хувь хэмжээгээ бууруулаад явах боломжтой компаниудыг бид Крипто Үндэстэн ХК, ТэнГэрЛиг Медиа Нэгдэл ХК, МОСТ Финтек Групп, ГрэйпСити Монгол Групп зэрэг нэгдэл компаниудад хувааж, хуваарилав. Монгол Шуудан ХК болон Улаанбаатар Үнэт Цаасны Бирж (UBX) тусдаа үлдсэн бөгөөд эдгээрт хийсэн бидний хөрөнгө оруулалт стратегийн шинж чанартай ч урт хугацаанд бид мөн л оруулсан хувь хэмжээгээ бууруулах ёстой гэж тогтсон юм. Ард Санхүүгийн Нэгдлийн хувьд цаашид хэрхэн, ямар бүтэц, орон тоотой ажиллах тал дээр дүгнэлт хийж байна - сонгодог хөрөнгө оруулалтын сангийн хэлбэрээр Ард Менежментэд гэрээгээр удирдлагаа шилжүүлээд явах боломжтой эсэхийг бид яг одоо судалж байгаа болно.

Үүний зэрэгцээ бид Нэгдлийн баланс дээрх өрийн үлдэгдэл, хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх үүднээс өрийг хөрөнгөөр сольж, боломжит охин компаниуддаа шилжүүлэв. Мөнгөний хүрэлцээг хангаж, хөрвөх чадвараа удирдах нь Ард Санхүүгийн Нэгдлийн хувьд өнгөрсөн жилийн хамгийн том сорилт байсан болно.

Холдинг компанийн хувьд охин болон хөрөнгө оруулалттай компаниуддаа аль болох мөнгөний дарамт үүсгэхгүй ажиллах үүднээс орон тооны цомхотгол хийж, нэгдлийн бүх түвшинд зардлын таналт, орон тооны хяналтыг тогтмол хэрэгжүүлж ирлээ. Манай багийн гишүүдийн тоо оны эхэнд 335 байсан бол оны эцэст 275 болж буурсан.

Санхүүгийн хувьд бид өмнөх жилүүдэд хийсэн хөрөнгө оруулалтын төлбөрийг зохих ёсоор барагдуулж ажиллалаа. Ард Холдингс 2023 онд нийт 20.4 тэрбум төгрөгийн өглөг зээлийг барагдуулж, 6.5 тэрбум төгрөгийн өрийг дахин санхүүжүүлэв.

Бидний ажлыг ямагт дэмжиж ирсэн түнш байгууллага, бидэнд итгэл хүлээлгэж ажилладаг харилцагчид, хөрөнгө оруулагчдадаа энд талархал илэрхийлэх нь зүйтэй байх. Байдал хэдийгээр хүнд байсан ч Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Кредит болон Ард Даатгал хувьцаат компаниуд өөрсдийн хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахаар шийдсэн юм.

"Манай компанийн хувьд МХБ дээр арилжаалагдаж буй 8 нээлттэй компанийг өөртөө нэгтгэсэн гэдгээрээ хамгийн олон компаниудын нэгдэл юм. Мөн 100 гаруй мянган хувьцаа эзэмшигчтэй болсон байгаа нь Монголын хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй компани болж чадсаныг илтгэнэ."

Чулууны Ганхуяг

2022 оны эхнээс авахуулаад бидний хамтран байгуулсан ТэнГэр ТВ бүрэн хэмжээнд ажиллаж эхэлсэн бол UBX дээр анхны IPO хийгдэхэд бэлэн болоод байна. DAX-ыг хааж, харилцагчдын хөрөнгийг амжилттайгаар хөрвүүлэн, idax Санхүүгийн Зохицуулах Хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл авав. Хөрөнгө Оруулагч Үндэстэн нэртэй Монголын анхны нээлттэй хамтын сан Ард Менежментийн дор зөвшөөрлөө авч, гарааны хөрөнгөө босгон ажиллаж эхэллээ.

 Тэрбум	₮137 хөрөнгө (тусдаа)	₮104 Эздийн өмч (тусдаа)	₮140 33Ү (МХБ: зөвхөн AARD)
	₮450 удирдлагад буй хөрөнгө (нийт)	₮133 Үнэлгээ (ЦХҮ)	₮416 33Ү (Нэгдлийн хэмжээнд)

2021 онд түршилтын журмаар эхлүүлсэн нийлүүлэлтийн гинжин хэлхээний санхүүжилтийн ГҮҮД платформ ажиллаж эхэлсэн бөгөөд энэ төслийн хүрээнд Гацууртын бондын эргэн төлөлт хийгдэж, Майндтек компанийн үйлдвэрлэдэг хүнсний тос болон малын тэжээлийг хэрэглэгчдэд хүргэж эхлэв. Одоогийн байдлаар бид 1,692 мерчантад 1 тэрбум гаруй төгрөгийн борлуулалт хийж, нийт 470 гаруй сая төгрөгийн зээлийг 1,800 гаруй малчдад гаргаад байна.

Банкны кластерын хувьд бид нийт 115 тэрбум төгрөгийн зээлийг 18,181 зээлдэгчдэд олгосон байна. Ард Кредит 2.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол Ард Активын ашиг 712 саятай гарлаа. Бид хоёрдогч өглөгөөр хэлбэрээр 5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Ард Кредитэд олгов.

Даатгалын кластерт багтах тэтгэврийн хуримтлалын үйлчилгээнд нийт 150 мянган хүн хамрагдаад байгаа бол даатгалын орлого 22.3 тэрбум төгрөг байж, 7.9 тэрбум нөхөн төлбөрийг олгов. Ард Даатгалын ашиг 736 сая төгрөгт хүрсэн боловч хөрөнгө оруулалтын багцүүд зах зээлээ дагаад унасан үзүүлэлттэй гарав. Өнгөрсөн оны хувьд бид амьдралын даатгалын тусгай зөвшөөрлийг авах гэж ажилласан боловч хараахан үр дүн гараагүй байна.

Хөрөнгө оруулалтын банкны кластер 47 тэрбум төгрөгийн хөрөнгө босгоход оролцсон бөгөөд Монголын хөрөнгийн бирж дээр нийт 65 тэрбум төгрөгийн арилжаа явуулав.

Улаанбаатар Үнэт Цаасны Биржид бид Б. Гантулгыг гүйцэтгэх захирлаар томилж, ажилд нь оруулсан бөгөөд шинэ хөрөнгө оруулагч татах, шинэ бүтээгдэхүүн гаргах том зорилтуудыг өмнө нь тавив.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл авах болсон idax биржид бид нэмэлт 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн бөгөөд idax Монголдоо шинэлэг олон үйлчилгээг нэвтрүүлж, амжилттай явсаар хамгийн том бирж болох замдаа шулуудан оров.

Оны сүүлчээр бид нийт 200 орчим мянган хүний дансанд идэвхгүй төлөвтэй болсон АрдКойныг буцаан авч, АрдКойн эзэмшигчдийн тоо Ард Апп дээр 390 мянга болов. Ард Апп дээр бүртгэлтэй нийт 1,300 мянган хүн байгаа бөгөөд ирэх он жилүүдэд тэдгээрийг идэвхжүүлэх ажлыг бид төлөвлөн гүйцэтгэхээр шамдан ажиллаж байна.

2022 онд Ардын ТУЗ нийт 5 удаа хуралдаж, эчнээ 24 санал хураалт явуулж, гишүүд ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэл, Хөрөнгө Оруулалтын болон Засаглал, Нэр Дэвшүүлэх, Цалин Урамшууллын хороонд идэвхтэй оролцож, компанийн ажлыг удирдлага чиглэлээр хангаж ирлээ. Нийт Нэгдлийн хэмжээнд 220 гаруй хүн давхардсан тоогоор Ардын компаниудын ТУЗ-д ажиллаж байна.

Оны сүүлчээр Ард Санхүүгийн Нэгдлийн зүгээс нийт Монголын хүүхэд бүрт хувьцаагаа үнэгүй эзэмшүүлэх аяныг Бид Илүү Байж Чадна уриан дор эхлүүлсэн бөгөөд нийт 45 мянга гаруй бяцхан үрс маань Ардын хувьцаа эзэмшигч боллоо. Энэ ажлын хүрээнд бид нийт 1 сая гаруй хүүхдэд хүрэх зорилго тавин ажиллаж байна.

2022 оны гүйцэтгэл дээр тулгуурлан компанийн ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрийг гаргасан хэдий ч бид Ард Санхүүгийн Нэгдлийн бүх хувьцаа эзэмшигчдэдээ хувьцаа тус бүрт нь хоёр АрдКойн хуваарилахаар тогтов.

2023 он гарсаар нөхцөл байдал эергээр эргэж байгаа дохио илэрч эхлэв - Монгол Улс хэдий ганц В зэрэглэлтэй ч өөрийн бондыг олон улсад амжилттай арилжиж, бондынхоо өртөг зардлыг бууруулан, гадаад өрийн удирдлагаа зохистой гүйцэтгэж, гадаад валютын нөөцөө нэмэгдүүлж эхлэв. 2022 оны эхний улиралд эдийн засаг 7.2 хувиар өсөж, инфляц 12 хувьтай гарснаас гадна Монгол төгрөг чангарах төлөвтэй боллоо. Хятад хилээ нээж, манай экспорт тогтвортой нэмэгдэж эхэлсэн бөгөөд Оюу Толгойн зэс, алтны уурхай бүрэн хэмжээний үйлдвэрлэл явуулж эхэлсэн нь Монголын эдийн засгийн төлөв байдлыг эрс сайжрууллаа.

2023 онд бид гадагшаа төлөх өр төлбөрийг огцом бууруулах зорилго тавин ажиллаж байна. Бидэнд нийт 40 орчим тэрбумын зээл болон бондын өрийг дарах шаардлага бий. Үүнийг дарахад бид хөрөнгө оруулалттай компаниудынхаа өөрийн эзэмшлийн хувьцааг худалдан борлуулахаар зэхэж байна.

Ард Актив хадгаламж зээлийн хоршоо маань өргөжин тэлсээр Монголдоо хоёрт эрэмбэлэгдэж эхэллээ. Ирэх он жилүүдэд бид Ард Активын үйл ажиллагааг улам бүр өргөжүүлэн тэлж, манай нийт хувьцаа эзэмшигчид, харилцагчдыг гишүүнээр элсүүлэх, Монгол Улс даяар үйл ажиллагаагаа явуулдаг хамгийн хүчирхэг сүлжээтэй банкны бүтэц болгон ажиллуулахыг зорилгоо болгон хөдөлж эхлээд байна.

2022 оны сүүлчээс бид Хөх Тэнгэр төслийг санаачлан эхлүүлэв. Энэ төслийн хүрээнд нийт Монголчуудад нийслэл хотынхоо зүрхэнд байрлах А зэрэглэлийн оффис, зочид буудлын зориулалттай Блю Скай Тауэр & Отэльд 1,000 төгрөгөөр ч болтугай хөрөнгө оруулан, түрээсийнхээ өгөөжийг хүртэх, мөнгөнийхөө үнэ цэнийг хатуу валютаар хамгаалах боломжийг нээхээр зориг шулуудан ажиллаж эхэллээ.

Улаанбаатар хотын иргэдийн хувьд утаа, түгжрэл, тоосжилт, шуугиан, орчны тав тух, ногоон байгууламжийн хомсдол хамгийн том дутагдал бэрхшээл болоод удсан. Тэгвэл бид Сонгинохайрхан дүүрэгт байрлах Найрамдал зуслангийн аманд 80 га газарт хөрөнгө оруулан, "Смарт Чартер Сити" төсөл дээр ажиллаж эхэллээ. Энэ нь Ардын хэрэгжүүлэх, хамгийн том санхүүжилт, хүч нөөц шаардсан төсөл болох нь дамжиггүй. Улс нийгэмдээ үзүүлэх үр нөлөө нь ч он жилүүдийг давсан аугаа байх нь тодорхой.

Шинэ Сэргэлтийн Бодлогын хүрээнд бид өнгөрсөн жил Монголын Эдийн Засгийн Форумыг ивээн тэтгэж, зохион байгуулалтад нь оролцов. Энэ жил "Welcome to Mongolia" уриан дор зохион байгуулагдах Форумыг бид дахин ивээн тэтгэж, гол зохион байгуулалтын багт нь орж ажиллахаар болов.

"Ард гэдэг нь бид бүхнийг хэлнэ. Нийлнэ, нэгдэнэ, бүтээнэ. Хувьцаа эзэмшигчид, компаниараа, багаараа нийлээд Хөрөнгө Оруулагч Үндэстнийг бий болгож байгаа юм."

Чулууны Ганхуяг

Бид Илүү Байж Чадна! Ард - Хүчтэй, Хамтдаа!

Гүнээ хүндэтгэн мэхийн ёсолсон,
Таны хувь эзэмшдэг Ардын захирал
Хутагт овогтой ЧУЛУУНЫ ГАНХУЯГ

	+96,030 хувьцаа эзэмшигч	1.05 сая Ард Апп хэрэглэгч	151,651 үнэт цаасны данс	105,816 даатгуулагч
	543,538 АрдКойн эзэмшигч	36,921 АрдКидс хэрэглэгч	9,702 зээлийн данс	151,685 тэтгэврийн хуримтлалын данс




Товч түүх

Анх 2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон АНУ-ын Мэрси Кор төрийн бус байгууллага ХасБанкны нийт ажиллагсдад зориулан тэдэнд хувьцаа эзэмшүүлэх санд 600 сая төгрөгийг хандивлахаар шийдвэрлэсэн түүхтэй. 2005 онд ХасБанкны ажиллагсад тус сангаас олгогдсон хувьцааны үнэ цэнийг өсгөх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх зорилгоор өөрсдийн хувьцаагаа нийлүүлж Employee Investment Trust буюу ИАЙТи ХХК-йг хамтдаа үүсгэн байгуулж ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн тодорхой хувийг авснаар Монголын анхны институционал хөрөнгө оруулагчийн суурь тавигдсан юм.

И Ай Ти нь үүсгэн байгуулагдах үедээ нийт 1.2 сая төгрөгийн дүрмийн сан, 10 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2022 оны жилийн эцсээр Ард Санхүүгийн Нэгдлийн хэмжээнд нийт 100 мянга гаруй (давхардсан тоогоор) хувьцаа эзэмшигчидтэй болсноос гадна 450 тэрбум орчим төгрөгийн хөрөнгийг удирдаж байна.

Хүн бүр бүтээсэн баялгаасаа хувь хүртэх, харилцагч иргэн бүр үйлчлүүлдэг банкныхаа эзэн нь байх ёстой гэсэн итгэл үнэмшилдээ бид хөтлөгдөн 2015 онд Ард Санхүүгийн Нэгдлийг хаалттай хувьцаат компани болгосон билээ. 2017 оны төгсгөлд Хөрөнгө Оруулагч Үндэстэн нь Жинст-Увс нээлттэй ХК-тай урвуу хэлбэрээр нэгдэж, Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдаж эхэлсэн бол 2019 оны 8 сарын 8-нд Ард Санхүүгийн Нэгдэл нь урвуу нэгдэл хийснээр нээлттэй хувьцаат компани болсон юм.

2013 онд И Ай Ти-гийн гол хувьцаа эзэмшигчид шинэ стратегийн зорилгоо тодорхойлж, Ард Санхүүгийн Нэгдэл гэх нэрийн дор үйл ажиллагаагаа явуулах түүхэн шийдвэрийг гаргасан. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд банк бус санхүүгийн байгууллага, даатгал, үнэт цаасны компани, тэтгэврийн сан, хадгаламж зээлийн хоршоо зэрэг санхүүгийн байгууллагуудад тасралтгүй хөрөнгө оруулж, нэгдэх, нийлэх ажлыг явуулж, 2016 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр болсон томоохон хувьчлалд амжилттай оролцож Монгол Шуудан ХК-ийн гол хөрөнгө оруулагч болж чадсан юм.



2017 онд үндсэн хөрөнгө оруулалтын багцад хөрөнгө оруулалтын менежментийн компани, блокчэйн болон криптовалютын чиглэлээр ажиллах Ард Бит компани, Кripto Үндэстэн Сан нэмэгдсэн бол 2018-2019 онд технологи, үл хөдлөх хөрөнгө, онлайн худалдаа, харилцагчийн үйлчилгээ, хөрөнгө оруулалт, лизингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах компаниуд байгуулагдаж, Нэгдлийн бүтцэд багтаж эхлэв.

2020 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдах анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Санг байгуулсан. Харин криптовалютын сангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Кripto Үндэстэн ХХК нь Булган Ундрага ХК-тай урвуу нэгдэл хийснээс гадна виртуал хөрөнгийн бирж болох DAX-ыг үүсгэн байгуулж, бүтцээ өргөжүүлэв.

2021 онд ТэнГэрЛиг Медиа Нэгдэл ХК, Улаанбаатарын Үнэт Цаасны Бирж хаалттай ХК-иудад хөрөнгө оруулж, МОСТ Финтек ХХК, Грэйп Сити Монгол ХХК-иудтай дараагийн шатны хамтын ажиллагааг эхлүүлсэн юм. Мөн ХАСҮ санг үүсгэн байгуулсан ба Төвлөрсөн бус санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүн болох АрдМааний төслийг эхлүүлэв.

2022 онд Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалтын багцад нийт 45 тусгай зөвшөөрөлтэй 44 компани багтаж байгаа ба тэдгээрийн талаар тус тайлангийн хөрөнгө оруулалт хэсгээс танилцаж болно.

▲ Алсын хараа

Бүс нутагтаа тэргүүлэгч
финтек нэгдэл болох.

▲ Эрхэм зорилго

Хөрөнгө Оруулагч
Үндэстэнг цогцлоох

Мөрдөх зарчим

- ▲ Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж ажиллана
 - ▲ Ёс зүйн хэм хэмжээг өндөрт тогтоон дагаж, хууль тогтоомжийг чандлан мөрдөхийн зэрэгцээ хүйсийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллана
 - ▲ Хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэлийн харьцааг зохистой түвшинд барьж ажиллана
 - ▲ Сайн засаглал, ил тод байдлыг байгууллагын бүх түвшинд нэвтрүүлэн ажиллана
 - ▲ Нээлттэй уян хатан бодлого баримталж, зах зээлийн мэдрэмжтэй, хурдан шуурхай ажиллахыг эрмэлзэнэ
 - ▲ Шинийг нэвтрүүлж, манлайлах бодлогыг мөрдөж ажиллана
 - ▲ Харилцагчийн үйлчилгээг дээд зэрэгт барих бодлогыг чандлан мөрдөнө
 - ▲ Хамгийн авьяаслаг, хүчирхэг, мэргэжлийн, цомхон, үйл хэрэгтээ үнэнч хамт олныг бүрдүүлж ажиллах бөгөөд шинээр ажилд орох босгыг өндөрт тогтоож, ажлын байранд тавигдах шаардлага, хариуцлагыг чанд мөрдөнө
 - ▲ Нийгмийн хариуцлага өндөртэй, нийгэмд эерэг өөрчлөлтийг түүчээлж ажиллана
 - ▲ Хууль эрх зүйн болон бизнесийн орчиндоо шаардагдаж буй өөрчлөлтүүдийг бий болгохын төлөө санаачилга гаргаж ажиллана
 - ▲ Байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалах шилдэг стандартыг нэвтрүүлж ажиллана
- Бүтээгдэхүүн үйлчилгээндээ өөрсдийн итгэл үнэмшил, философийг шингээж ажиллана.

Давуу шинж чанар

- ▲ Өрсөлдөх чадвар, үр ашиг болон дэвшилтэт технологийг цогцлуулсан түншлэл
- ▲ Амжилттай хөрөнгө оруулалтын туршлага, ил тод засаглал
- ▲ Шинэ санаа, төслийг хэрэгжүүлэгч олон улсад танигдсан хамт олон
- ▲ Хөрөнгө оруулалтын тогтвортой өгөөж
- ▲ Зах зээлийн боломжийг хөрөнгийн үнэ цэн болгох туршлага
- ▲ Хөрөнгө оруулагч үндэстний танигдсан брэнд
- ▲ Үндэсний хэмжээний цогц дэд бүтэц
- ▲ Энтрепренёр соёл.

2022 оны
онцлох үйл
явдал



2022 оны чухлыг онцолбол



Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Даатгал, Ард Кредит, Монгол Шуудан хувьцаат компаниуд Монголын хөрөнгийн биржийн ТОП 20 компанид дахин багтлаа.



Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Global Banking & Finance Review сэтгүүлийн 2022 оны Монголын шилдэг Санхүүгийн Нэгдэл компаниар шалгарлаа.



Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Даатгал, Ард Кредит хувьцаат компаниуд 2022 онд нийт 3.6 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ олголоо.



Монголын хойч ирээдүй болсон хүүхэд, багачуудынхаа төлөө илүү гэгээлэг, илүү сайн сайхан нийгмийг бүтээхийн тулд томчууд бид яг одооноос үр хүүхдэдээ эергээр нөлөөлөх энгийн алхмаас эхлэх хэрэгтэйг уриалан, Илүү Байж Чадна хөдөлгөөнийг өрнүүлж, Монголын насанд хүрээгүй хүүхэд бүрт Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааг үнэ төлбөргүй эзэмшүүлэх аяныг эхлүүлэв.

2022 онд санхүүгийн болон хөрөнгийн зах зээлд хэд хэдэн

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ

амжилттай нэвтрүүлж, харилцагчдын талархалыг хүлээгээд байна.



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН

Хөрөнгө Оруулагч Үндэстэн - Монголын анхны нээлттэй хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулж, Монголын Хөрөнгийн Биржид алтан үсгээр бичигдэх түүхийг бүтээлцлээ.



Ухаалаг Хөрөнгө Оруулагч - үнэт цаасны хуримтлалыг хөрөнгө оруулагчдадаа санал болгож, харилцагчдын хөрөнгө оруулалтын сонголтыг нэмэгдүүллээ.



CupCake - Худалдан авалтын хариултаа хадгалах үйлчилгээг нэвтрүүлэн, харилцагчдаа хуримтлалыг хэвшил болгох дадалд хөтөлж эхэллээ. Одоогоор 1,443 харилцагчид өдөр бүр тогтмол нийт 1.3 сая төгрөгийг хуримтлуулж байна.



Pick n Pay - Хуваан төлөх үйлчилгээг санал болгож эхэлсэн ба Ардын харилцагчид хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүүгүй, шимтгэлгүй хуваан төлөх боломжтой боллоо.



Ардын Эрх - урамшуулалт хөтөлбөрийг эхлүүлсэн ба энэ үйлчилгээ нь харилцагчдыг идэвхжүүлэх, санхүүгийн сахилга баттай байгааг нь дахин урамшуулах хөтөлбөр. Бүтээгдэхүүн, үйлчилгээндээ АрдКойны урамшууллыг авахаас гадна сард 1,000 Ардын эрх цуглуулаад, тухайн эрхээ 1,000 АрдКойн руу хөрвүүлэн, давхар урамшуулал авах боломжийг олгож буй юм.



АрдКидс - Хүүхдийн анхны санхүүгийн аппыг танилцуулсан ба өдгөө 40,000 гаруй хүүхэд, багачууд тогтмол ашиглан, санхүүгийн сахилга бат, хуримтлуулах зуршилд суралцаж байгаад талархалтай байна.



2022 онд бид Төв Шуудан дахь Монгол Шуудангийн салбар болон Дархан хотод үйл ажиллагаагаа тэлэн, санхүүгийн цогц үйлчилгээг нэг дороос авах, санхүүгийн мэргэжилтнүүдийн сургалтад хамрагдах, хөрөнгө оруулалтын талаарх мэдлэгээ тэлэх боломжийг харилцагчдадаа нээлээ.



Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2022

Цар тахлын нөхцөл байдлаас болж тасалдсан Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулганыг 2 жилийн дараа зохион байгуулах боломжтой болсон. Нийт 4,000 гаруй хүн оролцож, 100 мянга гаруй хүн шууд дамжуулалтыг үзсэн байна. 2016 оноос эхлэн Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох зорилготой зохион байгуулагдаж буй уг форум нь санхүү, хөрөнгө оруулалтын салбарын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн талаар бүх оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлдэг уламжлалтай.

Энэ нь санхүүгийн боловсролын хурдасгуур, төв болж, хүмүүст хөрөнгийн зах зээлийг ойлгоход тусалдаг. Чуулганы үеэр бид NFT худалдааны платформ болох Ard Art платформын нээлт, метаверс дэх шинэ санаачилга, ГҮҮД платформ зэрэг хэд хэдэн ажлуудаа танилцуулсан юм. Мөн чуулганы үеэр хувьцаа эзэмшигчид, ажилтнууд, ТУЗ-ийн гишүүд, салбарын мэргэжилтнүүд, удирдах ажилтнуудтай хийсэн ярилцлагуудаас бүрдсэн Хөрөнгө Оруулагч Үндэстэн нэртэй баримтат киног нээж, олон түмэнд толилуулав.





**Хувьцаа эзэмшигч,
бүтэц зохион
байгуулалт**





Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо

96,030



#	Хувьцаа эзэмшигч	2021	%	2022	%	Өөрчлөлт, тоо	Өөрчлөлт, %
1	И Ай Ти (Эйч Ви Эл Эл)	3,192,411	11.2%	3,353,247	11.7%	160,836	0.6%
2	Ардын Тэтгэврийн Данс	2,204,781	7.7%	2,237,311	7.8%	32,530	0.1%
3	Бруно Рашле	2,104,592	7.4%	2,106,396	7.4%	1,804	0.0%
4	А.Сүхдорж	1,226,377	4.3%	1,941,591	6.8%	715,214	2.5%
5	Ард Венчурс	1,470,419	5.1%	1,530,712	5.4%	60,293	0.2%
6	Ч.Ганхуяг	1,368,264	4.8%	1,439,148	5.0%	70,884	0.3%
7	Г.Уянга	1,381,936	4.8%	1,388,900	4.9%	6,964	0.0%
8	DAX (ARDT)	1,057,697	3.7%	847,917	3.0%	(209,780)	(0.7%)
9	Ард Лизинг	803,072	2.8%	761,207	2.7%	(41,865)	(0.2%)
10	Ард Секюритиз	962,620	3.4%	566,389	2.0%	(396,231)	(1.4%)
11	С.Гэрэлтуяа	455,935	1.6%	455,935	1.6%	0	0.0%
12	Ронкок Лимитед	479,111	1.7%	443,816	1.6%	(35,295)	(0.1%)
13	Ард Даатгал	411,455	1.4%	405,387	1.4%	(6,068)	(0.0%)
14	С.Оргил	283,800	1.0%	390,937	1.4%	107,137	0.4%
15	Г. Бат-Эрдэнэ	352,497	1.2%	351,268	1.2%	(1,229)	0.0%
Топ 15 хувьцаа эзэмшигчид		17,754,967	62.0%	18,220,161	63.7%	465,194	1.6%
Бусад хувьцаа эзэмшигчид		10,859,296	38.0%	10,394,102	36.3%	(465,194)	(1.6%)
Эргэлтэд буй хувьцаа		28,614,263		28,614,263			
Хувьцаа эзэмшигчид		18,793		18,188		(605)	
ARDT эзэмшигчид		6,591		2,990		(3,601)	




Пүрэвжаргал Батбаяр

ТУЗ-ийн дарга,
Ард Санхүүгийн Нэгдэл

ИБУИНВУ-ын Свонси хотын Уэлсийн их сургуулийг Эдийн засгийн бакалавр, Лондонгийн Бизнесийн Сургуулийг магистрын зэрэгтэйгээр тус тус амжилттай дүүргэсэн. П. Батбаяр нь 20 гаруй жилийн хугацаанд Лондон болон Улаанбаатар хотод банк, санхүүгийн салбарт ажилласан туршлагатай.

Тэрээр Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-нд 10 орчим жил ажиллахдаа Монгол Улсад уул уурхай, нефтийн хөрөнгө оруулалтын төслүүд хариуцсан төлөөлөгчөөр, мөн Зүүн Европ, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнууд болон Монголыг хамарсан уул уурхай, газрын тосны салбар дахь хэд хэдэн томоохон, шинэ төслүүдийг судалж, санхүүжилтийн гэрээ хэлцэл байгуулах, хэрэгжүүлэх ажлыг гардан гүйцэтгэсэн. Мөн Монгол Улсын тэргүүлэх, арилжааны банкны нэг Хаан Банк, худалдаа, үйлдвэрлэл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч Интергрупп ХХК болон уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг Олова ХХК-д тус тус удирдах алба хашиж байсан.

П.Батбаяр нь уул уурхайн зөвлөгөө, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг RMM Pty Ltd компанийн ТУЗ-ийн гишүүн болон Монголын Рагбигийн Холбооны Ерөнхийлөгчөөр давхар ажиллаж байна. 2014 оны 1 дүгээр сараас Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр, 2017 оны 8 дугаар сараас ТУЗ-ийн даргаар тус тус томилогдсон.



Чулууны Ганхуяг Ердийн гишүүн


Гүйцэтгэх захирал,
Ард Санхүүгийн Нэгдэл

Унгар Улсын Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг дүүргэсэн тэрээр 1991 онд Монголын Хөрөнгийн Биржээс хөдөлмөрийн гараагаа эхэлж, Монголбанкинд хянан шалгагчаар оржээ. 1998 онд НҮБ-ын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр Санхүүгийн менежерээр шалгаран ажиллаж байгаад 1999 онд Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Хөгжлийн Алтан Сан (ХАС)-г байгуулан, Гүйцэтгэх захирлаар томилогдсон юм.

ХАС нь бичил зээлийн үйл ажиллагааг амжилттай явуулсаар 2001 онд Говийн Эхлэл ББСБ-тай нэгдэж, өнөөгийн ХасБанк байгуулагдсан түүхтэй. Ч.Ганхуяг нь ХасБанк байгуулагдсан цагаас хойш 2009 оныг хүртэл Гүйцэтгэх захирлаар ажилласан бөгөөд 2009-2010 онд ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх захирал, 2010-2012 онд Монгол Улсын Сангийн Дэд сайдаар тус тус ажиллаж байв.

Тэрээр Унгар улсын өргөмжит консул, Монголын Эдийн Засгийн Форумын санаачлагч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Монголын Оюутны Холбооны Ерөнхийлөгч, Олон Улсын Бичил Санхүүгийн Төвийн ТУЗ-ийн гишүүн, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Ерөнхийлөгч гэх мэт албан тушаал хашиж байснаас гадна Монгол Улсад анхлан хадгаламж зээлийн хоршооны хөдөлгөөнийг 1990-ээд оны сүүлээр эхлүүлсэн.

2009 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумас түүнийг Дэлхийн Залуу Манлайлагчаар өргөмжилсөн. Мөн Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгчийн сонгуульт ажлыг давхар хашдаг. Ч.Ганхуяг нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд тус компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.





Бруно Рашле
Ердийн гишүүн

Дэд дарга,
Шродер Адвек

Швейцарын Холбооны Технологийн Институтыг барилгын инженерийн чиглэлээр, Стэнфордын их сургуулийг аж үйлдвэрийн инженер мэргэжлээр магистр зэрэгтэй төгссөн бөгөөд 1990 онд Харвардын Их Сургуульд дэвшилтэт менежментийн хөтөлбөрийг дүүргэсэн Бруно Рашле 1997 онд Адвек Группыг үүсгэн байгуулж, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаад 2017 онд компаниа Шродер Группд худалдсан байна.

Шродер Адвек нь хувийн хөрөнгө оруулалтын менежментийн төрөлжсөн үйлчилгээ үзүүлдэг компани юм. Тус компани нь харилцагч санхүүгийн байгууллагуудаас хуримтлуулсан 10 гаруй тэрбум долларын санг удирдаж, дэлхийн хэмжээнд анхдагч болон хоёрдогч зах зээл дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж байна.

Адвекыг үүсгэн байгуулахаас өмнө Бруно Рашле нь Швейцарийн Мотор-Колумбусын сангийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт ЭмСи Партнерс сангийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байжээ. Тэрээр 5 тивд байрлах, төрөл бүрийн аж үйлдвэрүүдийн төслийг эхлүүлэх, нэмэлт хөрөнгө оруулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх төсөл хөтөлбөрийг удирдсан туршлагатай.



Авирын Сүхдорж
Ердийн гишүүн

Үүсгэн байгуулагч
БСБ Сервис, ГрэйпСити
Монгол, МОСТ Финтек,

Украин улсын Киев хотын Политехникийн их сургуулийг компьютерын инженер мэргэжлээр төгссөн А.Сүхдорж нь 1975 оноос Улсын Төлөвлөгөөний комиссоос ажлын гараагаа эхэлж төд удалгүй Монгол Улсын төв банкны Тооцоолон Бодох төвийн даргаар томилогдон ажилласан.

Социалист тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэний дараахан 1991 онд Монгол Улсын анхны мэдээллийн технологийн компани болох БСБ группыг үүсгэн байгуулсан байна. БСБ группын ТУЗ-ийн дарга, ерөнхий захирлаар ажиллаж байх хугацаандаа 2000 онд банк санхүү, төлбөрийн шийдлийн программ хангамжийн компани болох ГрэйпСити ГрэйпСити Монгол ХХК-ийг үүсгэн байгуулж, 2001 онд сансрын холбооны үйлчилгээ үзүүлэгч Инкомнет ХХК-ийг байгуулсан юм. ГрэйпСити Монгол нь эдүгээ Монгол Улсын банк санхүү, төлбөрийн шийдлийн программ хангамжийн тэргүүлэгч компани болжээ.

Тэрээр Монголын Мэдээлэл Харилцаа Холбооны хөгжлийн түүчээлэгч бөгөөд банк санхүү, төлбөрийн секторын хөдөлгөгч хүч болсоор ирсэн. Өнгөрсөн 40 жилийн хугацаанд олон тооны амжилттай төслүүд хэрэгжүүлсэн ба 2008 онд улсын хэмжээний анхны төлбөрийн үйлчилгээний оператор компанийг байгуулж (Мост Финтек ХХК), 2012 онд цахим төлбөр тооцооны МОСТ Мони мобайл хэтэвч үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн юм.



**Одончимэдийн Одбаяр****Ердийн гишүүн**ТУЗ-ийн Дарга,
Ард Даатгал ХК

Зөвлөлт Холбоот Улсын Киев хотын Багшийн Их Сургуульд багш мэргэжлээр суралцсан. Монгол Улсын магистрант зэрэгтэй. АНУ-ын Флорида мужийн Техникийн Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд олон улсын эдийн засагч, 1997-2000 оны хооронд Отгонтэнгэр Их Сургуульд хуульч, эрх зүйч, 2017 онд АНУ-ын Бостон хотын Харвардын Их Сургуульд бизнес удирдлагын чиглэлээр тус тус суралцаж төгссөн.

О.Одбаяр нь Монгол Хятадын хамтарсан Төрийн Өмчит Улсын Үйлдвэрийн Газрын захирал, Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Атташе, Гуравдугаар нарийн бичгийн дарга, 2010-2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Алтай Холдинг ХХК-ийн Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байв.

2016 оноос Төрийн өмчит Эрдэнэс Монгол компанийн Бизнес хөгжлийн асуудал эрхэлсэн дэд захирлын албыг хашиж, төрийн өмчит аж ахуйн нэгж, стратегийн холбогдол бүхий ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, байгалийн баялгийг олборлох, боловсруулах, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн төслүүдийг удирдан, түүний үр өгөөжийг баялгийн сангаар дамжуулан Монгол Улсын нийт ард иргэдэд хүртээх ажлыг хийж гүйцэтгэжээ.

**Чулууны Мөнхбат****Хараат бус гишүүн**(Ерөнхийлөгч,
Саусгоби Сэндс

ОХУ-ын Ленинград хотын дээд сургуулийг хуульч мэргэжлээр төгссөн ба Монгол Улсын Удирдлагын академийн Төрийн удирдлагын магистр, Шинэ Зеланд Улсын Вайкато их сургуульд Төрийн бодлого, удирдлагын чиглэлийн магистрын зэрэг хамгаалсан. Ч.Мөнхбат нь 2015 оны 9 сарын 7-ны өдрөөс Саусгоби Сэндс ХХК-ийн Ерөнхийлөгч мөн Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.

Ажлын гараагаа Саусгоби Ресурс компанид Зөвлөхөөр ажиллаж эхлүүлсэн бөгөөд улмаар Саусгоби сэндс ХХК-ийн Засгийн газрын харилцаа, Бодлогын хэрэгжилт хариуцсан захирлаар ажиллаж байв. Үүний өмнө тэрбээр Азийн Хөгжлийн Банкнд Төслийн захирлаар, Дэлхийн Банкнд Зохицуулагчаар тус тус ажиллажээ. Ч.Мөнхбат нь Шинэ Зеландын Монгол Улс дахь "Өргөмжит консул" юм.





Мөнх-Очирын Сэргэлэн
Хараат бус гишүүн

Захирал,
Монгол Коосэн Технологийн Коллеж

Япон улсын Исити коллежийг менежментийн чиглэлээр, Бизнес, олон улсын дээд сургуулийг нягтлан бодогчоор тус тус төгссөн. М.Сэргэлэн нь Техник Технологийн Дээд сургуулийн Ерөнхийлөгч, Монгол Коосэн Коллежийн захирлаар тус тус ажиллаж байна.

Тэрээр TCI компанийн захирал, MAC компанийн захирлаар тус тус ажиллаж байв. 2018 оны 5 сараас Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж эхэлсэн.



Михаил Зелдович
Хараат бус гишүүн

Хяналтын зөвлөлийн дарга,
Кокуун капитал

Харвардын Хуулийн сургууль болон Флетчерийн Хууль, Дипломатын сургууль төгссөн. Михаил Зелдович хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулах, худалдааны хэлэлцээр хийх, зөвлөгөө өгөх ТУЗ-ийг удирдсан 20 гаруй жилийн туршлагатай, мэргэшсэн хөрөнгө оруулагч бөгөөд түүхий эдийн арилжаа эрхлэгч юм. Тэрээр 2.2 тэрбум долларын хөрөнгө оруулалтын сангийн менежерээр ажиллаж байсан ба Бостон Консалтинг Группын зөвлөх, АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын худалдааны хэлэлцэгчээр тус тус ажиллаж байв.

Одоогоор Михаил Зелдович нь Зүүн Өмнөд Азийн үр тарианы хөрөнгө оруулалтын сан Кокуун Капиталын ТУЗ-ийн даргаар ажиллаж байгаа ба ногоон технологи, хөдөө аж ахуйн технологи, цахим аюулгүй байдал, байгалийн баялгийн салбарт бие даан хөрөнгө оруулдаг.

Мөн дэлхийн зах зээл дээр түүхий эд арилжаалагч Трафигура компанийн бүс нутгийн тэргүүнээр 10 гаруй жил ажиллаж байна. Монгол Улсын эрчим хүчний хараат бус байдалд оруулсан хувь нэмрийг нь төрөөс өндрөөр үнэлж, түүнийг Алтан гадас одонгоор шагнажээ.





Арно Вентура
Хараат бус гишүүн

Удирдах партнер,
Гожо энд Компани

Арно Вентура нь бичил, жижиг бизнесүүд рүү чиглэсэн, Африк тив, Хятад улсад тэргүүлэгч дижитал бичил санхүүгийн групп болох Баобаb Группын үүсгэн байгуулагч.

Баобабын эрхэм зорилго нь үйлчлүүлэгчдэдээ энгийн, амар хялбар санхүүгийн үйлчилгээ үзүүлэх замаар тэдний боломж бололцоог нээхэд туслах явдал юм. 2005 онд МикроКредит нэртэйгээр үүсгэн байгуулагдсан тус компани нь 2018 онд 1 тэрбум евротой тэнцэх санхүүжилтийг цахимаар болон мянга гаруй салбар, үйлчилгээний цэгүүдээрээ дамжуулан олгосон. Баобаb нь Африк, Хятадад үйл ажиллагаагаа явуулдаг 4,000 гаруй ажилтантай бөгөөд 1 сая орчим харилцагчидтай.

Баобабыг үүсгэн байгуулахаас өмнө Арно Вентура нь Планет Финанс гэх олон улсын хөгжлийн болон бичил санхүүгийн салбарт тэргүүлэх, олон улсын байгууллагыг үүсгэн байгуулахын сацуу Позитив Экономик Форум хэмээх нийгэмд чиглэсэн, Европын томоохон чуулга уулзалтыг санаачлан, хамтран зохион байгуулж байв.

Арно 2005 онд Францын, мөн 2013 онд Дэлхийн эдийн засгийн форумаас “Дэлхийн залуу удирдагч”-аар тус тус нэрлэгдсэн байна.

Планет Финансыг үүсгэн байгуулахаасаа өмнө тэрээр Франц, Аргентинд БНП Парибас банкинд ажиллаж байсан бөгөөд Франц, Тайландад тэргүүлэх интернетийн үйлчилгээг ханган нийлүүлэгч компанийг үүсгэн байгуулах ажилд гар бие оролцжээ.



ТУЗ-ийн гишүүдийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг

#	Хувьцаа эзэмшигч	2021	%	2022	%	Өөрчлөлт тоо
1	Бруно Рашле	2,104,592	7.4%	2,106,396	7.4%	1,804
2	А. Сүхдорж	1,226,377	4.3%	1,941,591	4.3%	715,214
3	Ч. Ганхуяг	1,368,264	4.8%	1,439,148	4.8%	70,884
4	П. Батбаяр	90,728	0.3%	90,008	0.3%	(720)
5	М. Сэргэлэн	62,335	0.2%	64,911	0.2%	2,576
6	Ч. Мөнхбат	36,786	0.1%	39,430	0.1%	2,644
7	Арно Вентура	13,923	0.0%	17,637	0.0%	3,714
8	О. Одбаяр	7,091	0.0%	2,649	0.0%	(4,442)
9	Михаил Зелдович	0	0.0%	3,383	0.0%	3,383
Нийт		4,910,096	17.1%	5,705,153	19.9%	795,057

**Чулууны Ганхуяг**

Унгарын Будапешт хотын Корвинус
Эдийн Засгийн их сургууль
Санхүүч

Гүйцэтгэх Захирал**Батбилэгийн Золбоо**

АНУ-ын Нью-Йорк
Мужийн их сургууль
Санхүүч

Санхүү Эрхэлсэн Захирал**Жаргалангийн Алтангүний**

Тайваны Үндэсний Шинжлэх
Ухааны их сургууль
Бизнесийн удирдлага - Магистр

**Олон Нийтийн Харилцаа
Эрхэлсэн Захирал****Гантөмөрийн Гантуяа**

БНСУ-ын Пусаны их сургууль
Мэдээлэл, Харилцаа Холбооны Технологийн
бодлого боловсруулагч - Магистр

Технологи Эрхэлсэн Захирал**Мөнхбатын Мөнх-Эрдэнэ (CPA, CPTA)**

Мандах их сургууль
Банк санхүү, нягтлан бодогч
Аудитор, Мэргэшсэн нягтлан бодогч

Дотоод Аудитор**Эрдэнэбаатарын Төртогтох**

Японы Иватэ их сургууль
Хэрэглээний математик,
загварчлал - Магистр


Эрсдэл Эрхэлсэн Захирал**Буяндэлгэрийн Уянга**

Монгол Улсын их сургууль
Бизнесийн удирдлага, Эрх зүйч

Хүний Нөөц Эрхэлсэн Захирал**Ганхуягийн Сэлэнгэ (CPA, CPTA)**

Мандах их сургууль
Нягтлан бодох бүртгэл, хяналт

Ерөнхий Нягтлан Бодогч




Гүйцэтгэлийн тайлан


Үйл ажиллагааны орчин

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын эдийн засаг 2020 онд 4.6 хувиар агшиж байсан бол 2021 оны 1.6 хувийн нам түвшний өсөлтөөс Орос - Украины дайн, цар тахал үргэлжилсэн жил болох 2022 онд 4.8 хувиар, харин 2023 оныг илүү өөдрөг, эерэг сэргэлтээр төсөөлбөл 6-7 хувиар өсөх төлөвтэй байна.


Жилийн дундаж инфляц, %




Гадаад худалдааны тэнцэл, тэрбум ам.доллар




M2 мөнгөний нийлүүлэлт, MNT триллион



ДНБ өсөлт, %



Эдийн засаг, зах зээлийн мөлхөө цаг үед инфляц хоёр оронтой тоонд хүрсэн сөрөг орчинд Монгол Улс урьдчилж харах боломжгүй гэнэтийн цочролууд, хосолмол эрсдэлтэй нүүр тулсан цаг хугацаа өнгөрлөө. Мөнгөний хатуу бодлого үргэлжилсэн хэдий ч 2022 оны төгсгөлд инфляц өндөр түвшинд хадлагдсанаар Монголбанк бодлогын хүүг 13 нэгжид хүргэв. Бодлогын хүүний өсөлт хөрөнгийн зах зээлийн өсөлттэй урвуу хамааралтай агаад, бас нэгэн томоохон сорилт нь валютын ханш төгрөгийн эсрэг чангарсан (USD 21%, EUR 15%, CNY 13%) явдал байлаа.



Гадаад худалдааны нийт барааны эргэлтийн хэмжээ 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 5,158 сая доллароор өсөж, 21,245 сая долларт хүрсэн байна. Үүнд экспорт 36%-иар буюу 3,299 сая доллароор, импорт 27%-иар буюу 1,859 сая доллароор өссөн нь нөлөөлөв. Тайлант онд худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 1,439 сая доллароор өсөж, 3,834 сая долларын ашигтай гарлаа. Төлбөрийн тэнцэл 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 727.2 сая долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оноос 505.6 сая доллароор өссөн байна.



2023 он дөнгөж гарахтай зэрэгцэн олон улсын судалгаа, шинжилгээний байгууллагууд энэ оныг эрсдэл-асуудал дүүрэн байх төсөөллийг танилцуулсаар - улсуудын бодлогын хүү төдийлөн буурахгүй, инфляц өндөр түвшинд байна, эдийн засгийн өсөлт дайн, ковидын нөлөөгөөр нам түвшинд хадгалагдана гэх мэт.

Эерэг талдаа бидний урд хөрш ковидын хатуу хөл хориогоо сулруулан, хилээ нээж буй сайн, мүү мэдээг дэлхий нийтэд нэгэн зэрэг дуулгасан бол Оюу толгой компанийн далд уурхай нь 2023 оны эхний хагаст Панел-0 хэсгийн тогтвортой үйлдвэрлэлийг ханган ажиллах хүлээлттэй байна.

Сөрөг талдаа Монгол Улсын Засгийн газар мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж буй цаг үед төсвийн тэлэх бодлого баримталж анх удаа 20 их наядыг давсан төсвийг батласан. Үүнд, ирэх оны нэгдсэн төсвийн нийт орлогыг өнгөрсөн оныхоос 20.4% нэмэгдүүлэн ₮19.6 их наядад хүрнэ гэж тооцоолсон бол, нийт төсвийн орлогын 87%-ийг татварын орлого бүрдүүлэх бөгөөд татварын орлогын төсөөллийг өнгөрсөн жилийнхээс 25.2% нэмэгдүүлсэн аж.

Ард Апп

2021	2022
625k	8.3k
шинэ харилцагч	
62.6	94.9
тэрбум төгрөг цахим зээл	
45.9	16.0
тэрбум төгрөг үнэт цаасны арилжаа	
744.3	369.7
тэрбум төгрөг шилжүүлэг	
6.2	6.0
тэрбум төгрөг хадгаламж	
178.2	78.2
сая ширхэг урамшууллаар олгосон АрдКойн	




Ард Апп v5.0
Тун удахгүй

АрдКидс

2022 онцлох хөгжүүлэлт

- Хөрөнгө Оруулагч Үндэстэн сан
- 6/42 Лотто
- Тэтгэврийн хуримтлалын шинэ систем
- Гуравдагч байгууллагын харилцагчид АрдКойны урамшуулал олгох API
- QPOS систем
- Иргэний үнэмлэх баталгаажуулалтыг хасав
- Ард аппын шинэ хувилбарыг хөгжүүлж байна.



Хөрөнгө оруулалт

Ард Санхүүгийн Нэгдэл нь стратегийн болон тактикийн хөрөнгө оруулалт хийдэг. Стратегийн хөрөнгө оруулалтын багцад санхүүгийн цогц үйлчилгээг нэг сүвгаар үзүүлэх компаниуд ордог ба тухайн компаниудын өсөлт хөгжилд санхүү болон менежментээр тасралтгүй хөрөнгө оруулж ирсэн.

Бид хөрөнгө оруулалтын бүтцээ жил бүр нэмэгдүүлж, бизнесийн бүтцийн хувьд босоо болон хөндлөн тэлэлт хийсээр ирсэн билээ. 2022 онд Нэгдэл нь хөрөнгө оруулалтын багцын бүтцээ үйл ажиллагааны чиглэл болон менежментийн цар хүрээнээс хамааран багцалж дараах кластеруудыг байгуулсан:

Хамааралтай удирдлагатай

Банк санхүү

Даатгал

Хөрөнгө оруулалтын банк

Бие даасан удирдлагатай

Дэд бүтэц


Крипто

Платформ

Мэдээлэл технологи

Медиа


Нэгдэл нь санхүүгийн компаниудын стратеги болон үйл ажиллагаанд оролцож, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгийн үнэ цэнийг өсгөх зорилгоор нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх бөгөөд тус компаниудад олонхийн эзэмшилтэй байна. Бусад чиглэлд үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын хувьд бие даасан удирдлага хэрэгжүүлэх бөгөөд Нэгдлийн санхүүгийн компаниудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор хамтран ажиллахаас гадна өөрсдийн зах зээлдээ тэлэх, гуравдагч талуудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ санал болгон хамтран ажиллахад илүү оновчтой болж байна. Тиймээс Нэгдэл нь бие даасан удирдлагатай компаниудад цөөнхийн эзэмшилтэй байх хөрөнгө оруулалтын стратегийг баримтлан ажиллана. Энэхүү стратегийн хүрээнд тус кластерын компаниудыг нэгтгэж нийлүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.




Хүний Нөөц

Нэгдлийн хэмжээнд 2022 оныг нийт 276 үндсэн ажилтантай үдсэн ба тэдгээрийг тоон мэдээлэл:

Хүйсээр




62.32%



37.68%

Ажиллаж буй хугацаагаар



Ажиллах хэв маяг өөрчлөгдөж, үнэ цэн утга учиртай амьдрах хэрэгцээ шаардлагыг мэдрэн ажил олгогчийн зүгээс ажиллагсдад уян хатан цагийн горим, үр дүн зорилгод чиглэсэн бүтээмж хамтын ажиллагааг дэмжих болон орчин нөхцөл, сэтгэл зүйн болон санхүүгийн сэтгэл ханамжтай ажиллах, хамтрах боломжийг бүхий л талаар олгоход чиглэн ажиллалаа.

Дотоод болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт хөгжлийн хөтөлбөрүүд болон нийт ажиллагсдын дунд тогтмол зохион байгуулдаг арга хэмжээнүүдийг хамт олны уур амьсгал, хамтач байдал, сурч хөгжих боломжийг ажилтнаа сонсох, тэдний хэрэгцээ шаардлагыг нэн тэргүүн харгалзан үзэхийг эрмэлзэлээ. Тэдгээрээс онцолбол:

- ▲ 1 сарын 1 Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлав. Сургагч багш 2022 хөтөлбөр хэрэгжив.
- ▲ 2 сарын 25 Ард Санхүүгийн Нэгдлийн нийт ажиллагсдын чуулга уулзалт болов.
- ▲ 3 сарын 20 Төслийн удирдлагын сургалт болон Ардын захирлуудын амралтын өдрийн сургалтууд нэгдүгээр улиралд зохион байгуулагдав.
- ▲ 4 сарын 30 Хөрөнгө оруулагч үндэстэн чуулган болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлуудын зохион байгуулалтад нийт ажиллагсад оролцов.
- ▲ 5 сарын 16 Тэрбум мод аяны хүрээнд өнгөрсөн жил тарьсан модоо арчлан, шинээр мод нэмж тарив.
- ▲ 6 сарын 20 Нийт ажиллагсдыг хамарсан Сэтгэл ханамжийн судалгааны дүн өнгөрсөн онтой харьцуулахад 30 орчим хувиар нэмэгдсэн.
- ▲ 7 сар Орон нутгийн ажиллагсдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, туршлага солилцох 7 хоногийн хөтөлбөр хэрэгжив.
- ▲ 8 сарын 10-13 Эм Би Жи эмнэлэгтэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэг оношилгооны өдөрлөг зохион байгуулав.
- ▲ 9 сарын 10 Нийт ажиллагсдын Зуны өдөрлөгөөр явган аялал, спорт уралдаан тэмцээн зохион байгуулав.
- ▲ 10 сарын 15 Сэтгэцийн эрүүл мэндийн сургалт болов.
- ▲ 11 сар ЕБС болон Их сургуулийн нээлттэй өдөрлөг, санхүүгийн мэдлэг түгээх сургалт танилцуулгыг Бритиш сургууль, УБ дахь Америк сургууль, Сурагчдын холбоо, Томужин алтернатив сургууль, Нест эдүкэйшн, Мандах их сургуулиудтай тус тус хамтран ажиллав.
- ▲ 12 сарын 30 Бид Илүү Байж Чадна аяны хүрээнд нийт ажиллагсдын хүүхэд бүрт 10 ширхэг хувьцаа, мөн Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ажилтан бүрт ₮1 сая тэнцэх AARD хувьцааг олгов.

Эрсдэлийн удирдлага

2022 оны хувьд цар тахлын нөлөө хараахан сайжраагүй байсантай зэрэгцээд Орос-Украины дайн дэгдсэнээр дэлхий даяар тодорхойгүй, тогтворгүй байдал үргэлжилж – эдийн засгийн томоохон хямрал нүүрлэсэн хэдий ч холдингс болоод түүний охин, хараат компаниуд эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлж, эрсдэлүүдээ хүлээн зөвшөөрөх хэмжээнд удирдан, хянаж ажиллалаа.


Эрсдэлийн засаглал

ТУЗ нь группын эрсдэлийн удирдлагын гол чиглүүлэгчийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн засаглал болон эрсдэлийн соёлыг бүрдүүлэхэд ерөнхий чиг үүргээр хангадаг бол ТУЗ-ийн дэргэдэх Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороо нь группын эрсдэлийн удирдлагын бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинг хянаж, батлах, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавьдаг.

Холдингсын Санхүү, Эрсдэлийн хороо нь кластер бүрийн онцлогт тохирсон учирч болзошгүй эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, бууруулах зөвлөмжийг өгч, компани бүрийн эрсдэлийн нэгж-хороодтой уялдаатай хамтран ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Ард Санхүүгийн Нэгдэл нь бүс нутагтаа тэргүүлэгч ФинТек нэгдэл болох алсын хараатайн хувьд эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй-оновчтой хэрэгжүүлэхийн тулд “Байгууллагын эрсдэлийн удирдлага”-ыг бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.




Хамгаалалтын гурван шугам

Байгууллагын эрсдэлийн удирдлагын зохистой засаглалын дагуу “Хамгаалалтын гурван шугам”-ын загвараар эрсдэлийг удирдах үүрэг хариуцлагуудыг тохиромжтой байдлаар хуваарилан хэрэгжүүлж байна.

Кластерын эрсдэлийн удирдлага

Холдингс нь үндсэн гурван кластерт хамаарах компаниудын эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэмжээнд удирдан, хянаж ажилладаг бөгөөд кластер бүрийн эрсдэлийн төрөл, хүлээн зөвшөөрөгдөх түвшин, түүнд тохирсон эрсдэлийн үнэлгээний аргачлал, загвар ашигладаг юм.




Хууль, хянан нийцүүлэлт

Ард Санхүүгийн Нэгдэл нь өөрийн үйл ажиллагаандаа болон хөрөнгө оруулалттай компаниуддаа менежментийн, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэхдээ бизнесийн орчинд хэрэглэгдэж байгаа хууль эрх зүйн актуудыг мөрдөхийн зэрэгцээ хөгжлийн үйл явцад нөхцөл шаардлагаас байнга үүсэж байдаг өөрчлөлтүүдийг эрх бүхий байгууллагуудаас холбогдох хууль, журамд оруулах санал авах ажлын хүрээнд идэвх санаачилга гарган ажилладаг. Компаенсын ажилтан нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хуулийн хянан нийцлийг хангаж, компаенсын хяналтыг зохион байгуулахад мэргэжлийн чадвар, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин, бие даасан хараат бус байдлаар ажиллах боломжийг эрх бүхий этгээдээс хангаж, дэмжлэг үзүүлж ажилладаг.

Ард Санхүүгийн Нэгдэл нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан холбогдох журмууд, компаниас баталсан дотоод журмууд болон Компанийн засаглалын кодекс зэргийг мөрдөж ажиллахаас гадна олон улсын гэрээ конвенц, олон улсын стандартын шаардлагыг баримтлан ажиллаж байна.

Маркетинг

Бүтээлч үйлдвэрлэл (Creative) кластераас танилцуулсан өнгө төрх, брэндингийн судалгаанд үндэслэн, бид брэндийн өнгөнд нэмэлт өөрчлөлт оруулж, улаан өнгийг үл ялиг зөөлрүүлэн дизайндаа уусгалттай өнгийг нэвтрүүлсэн юм. Мөн маркетингийн үйл ажиллагаандаа видео бичлэг (ялангуяа богино хэмжээний видео) түлхүү ашиглахыг чухалчлах болсон бөгөөд ихэнх компаниуд Facebook, Instagram Reels ашиглан бүтээгдэхүүнээ таниулан түгээж байна. Түүнчлэн, бид контентуудаа түргэн шуурхай бэлтгэн нийтлэх зорилгоор контент захиалах, явц харах, батлах дамжлага бүхий системийг нийт маркетингийн ажиллагсдадаа нэвтрүүлэн, хэвшүүлэв.



Дэлхийд анх удаа Хүннү рок чиглэлийн "The HU" хамтлагийн виртуал тоглолтыг Метаверс орчинд зохион байгуулахаар ажиллаж эхлэв.



Группын маркетинг бүтцийн өөрчлөлттэй уялдуулж, үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд маркетингийн багийг Банкны үйл ажиллагаа ба Хөрөнгийн зах зээл, Даатгал, Технологи, Платформ, Медиа, Бүтээлч үйлдвэрлэл, Дата анализ гэсэн 7 кластерт хуваан ажиллаж байна. Ингэж хувааснаар нэг кластер дахь компаниуд маркетинг, идэвхжүүлэлтийн ажлуудаа уялдуулан, хослуулахад илүү хялбар болсон.

ТэнГэрЛиг Медиа Нэгдэлтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хамтын ажиллагааг улам нягт болгох зорилгын хүрээнд Монгол HD, ТэнГэр телевизийн Монгол Наадам, Шинэ жилийн тусгай дугаарын шууд дамжуулалтын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллав.



Санхүү, бизнесийн салбарт шинэ салхи оруулж, үзэгч түмний сайшаал, магтаал хүртээд байгаа Аппрентис Монгол шоуны 2-р улирал 2022 оны 12-р сард цацагдаж эхэлсэн ба санхүү, бизнесийн мэдлэг, боловсролыг түгээж буй томоохон ач холбогдолтой бүтээл юм.





**Хөрөнгө
оруулалтын
багц**



САНХҮҮГИЙН БИРЖ
EXCHANGE



Хөрөнгө оруулалтын багц



Ард Кредит ББСБ (MSE:ADB)



Онцлох үйл явдал

- ▲ ББСБ-уудаас анх удаа карт гаргагчийн зөвшөөрөл авав.
- ▲ 6.9 тэрбум төгрөгийн хаалттай бонд гаргах зөвшөөрөл авч, амжилттай татан төвлөрүүлэв.
- ▲ Нийлүүлэлтийн гинжин хэлхээний СКОПА төслийг хамтран хэрэгжүүлж, төслийн хүрээнд малын тэжээлийн зээл, мерчантын зээлийн үйлчилгээг шинээр нэвтрүүлэв.
- ▲ Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс болон Монголын Хөрөнгийн Биржийн Хувьцаат компанийн I ангилалд дахин багтав.

Ард Актив ХЗХ

Онцлох үйл явдал

- ▲ Хадгаламж зээлийн хоршооны салбарт нийт хөрөнгөөрөө тэргүүлэх ТОП хоёр хоршооны нэг болов. Нийт хөрөнгөө 4.2 хувиар нэмэгдүүлж 31.5 тэрбум төгрөг, зээлийн багцыг 23 хувиар нэмэгдүүлж 25.5 тэрбум төгрөг, хадгаламжийн багцыг 2.5 хувиар нэмэгдүүлж 21.9 тэрбум төгрөг, ашигт ажиллагааг 75 хувиар нэмэгдүүлж 712 сая төгрөгт тус тус хүрлээ.
- ▲ "Ирээдүйн - Эзэн" нийлмэл хүүтэй хүүхдийн хадгаламжийг Ард Апп - АрдКидс апп ашиглан зайнаас хүссэн үедээ нээх боломжтой болж, хүүхдийн хадгаламжийн багц 1 тэрбум төгрөгт хүрэв.
- ▲ Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон дэлхийн хуримтлалын өдрүүдэд хуримтлалын ач холбогдлын тухай гишүүддээ сургалт, нээлттэй өдөрлөгийг зохион байгууллаа.



Хэмжих нэгж: тэрбум.төгрөг
CAGR: 2020 vs 2022

Даатгалын кластер

Ард Даатгал (MSE:AIC)

Онцлох үйл явдал

- Хувьцаа эзэмшигчдэдээ 1 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваариллаа.
- Нөхөн төлбөрийн үйлчилгээгээр 7,675 даатгалын тохиолдолтой холбоотой 7.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлж өмнөх жилээс 60 гаруй хувийн өсөлттэйгөөр даатгуулагчдын өмнө хүлээсэн даатгалын гэрээний үүргээ бүрэн биелүүллээ.
- Улсын Нийгмийн даатгалын санд 500 сая төгрөгийг, татварт 1.2 тэрбум төгрөг төлсөн байна.
- 2022 онд эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг таниулах, даатгуулсан харилцагчдаа халамжлах, зөвлөгөө мэдээллээр хангах зорилгоор давхардсан тоогоор нийт 156 байгууллагын 4,680 хүмүүст сургалт оржээ.

Ардын Тэтгэврийн Данс

Онцлох үйл явдал

- Тэтгэврийн хуримтлал эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсөх нөхцөлтэй тэтгэврийн хуримтлалын дансанд 2021 оны хөрөнгө оруулалтын өгөөж болох 22 хувийн өгөөж хуваарилав.
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж, хүссэн хугацаандаа тэтгэвэрт гарах боломжтой болж, гэрээ байгуулах хугацаанаас хамаарсан өгөөжийн өөрчлөлтийг нэвтрүүлэв.
- Тогтмол орлого хийдэг харилцагчдадаа зориулж хөнгөлөлттэй үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээ авах боломж олгох "Pension box" хөтөлбөр хэрэгжүүлж эхлэв.
- Шинэ жилийн баярыг тохиолдуулан Тэтгэврийн хуримтлал эзэмшигч компаниудын ажиллагсдын хүүхэд бүрт 3 ширхэг Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа болон 1,000 ширхэг АрдКойн бэлэглэв.



Нийт хөрөнгө

72.2

▲ 22.1%

Хөрөнгө оруулалтын багц

58.9

▲ 80.9%

Нийт орлого

24.7

▲ 20.0%

Тэтгэврийн сан

26.7

▲ 202.1%

Хэмжих нэгж: тэрбум.төгрөг
CAGR: 2020 vs 2022

Хөрөнгө оруулалтын банкны кластер

Ард Менежмент


Онцлох үйл явдал

- Монголын анхны хамтын нээлттэй сан болох Хөрөнгө Оруулагч Үндэстэн санг (ХОҮС) амжилттай үүсгэн байгуулж, 2022 оны эцсээр үйл ажиллагааг нь эхлүүллээ. Тус сан нь одоогоор 946 хөрөнгө оруулагчтай бөгөөд 2.5 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгөтэй байна. Үйл ажиллагаа явуулсан 2 сарын хугацаанд сангийн хөрөнгө оруулалтын багц 8.47%-ийн өгөөжтэй байна. Энэ нь жилээр тооцвол хүлээгдэж буй өгөөж нь 50.8% бөгөөд анх төлөвлөж байсан зорилтот өгөөжөөс даруй 13 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм.
- Монгол улсын хувьчлалд оролцож, түүнээс бий болох өгөөжийг хөрөнгө оруулагчдадаа хуваарилах зорилготойгоор 2020 онд үүсгэн байгуулагдсан хамтын хаалттай сан болох Үндэсний Хувьчлалын Санг (ХОС) нь банкны реформ, Монголын Хөрөнгийн Биржийн хувьчлал зэрэгт оролцон, хөрөнгө оруулалт хийлээ. ХОС-ийн хувьд жилийн эцсээр 6,127 нэгж эрх эзэмшигчидтэй, 7.05 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгөтэй байсан ба анх үүсгэн байгуулагдсанаасаа хойш 41.0%-ийн өгөөжтэй ажилласан байна.
- Ард Менежмент компанийн хувьд хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэн, 1 тэрбум төгрөгт хүргэх зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авлаа. Ингэснээр Компани нь хөрөнгө оруулалтын сангуудыг үүсгэн байгуулах, тэдгээрт хөрөнгө оруулах эх үүсвэрээ амжилттай нэмэгдүүлж чадлаа.

Ард Секюритиз

Онцлох үйл явдал

- Ард Секюритиз ҮЦК нь Монголын Хөрөнгийн Биржийн хувьцаа болон сангийн нэгж эрхийн арилжааны 65 тэрбум төгрөгийн арилжааг зуучилж, хувьцааны арилжаагаар ТОП гурван Үнэт Цаасны Компани (ҮЦК)-ийн нэгээр шалгарлаа.
- "Хөрөнгө Оруулагч Үндэстэн" нээлттэй сангийн анхдагч арилжааг зуучилж, хоёрдогч зах зээлд клиринг болон арилжааг зохион байгуулж байна.
- "Ухаалаг Хөрөнгө Оруулагч" үнэт цаасны хуримтлалын бүтээгдэхүүнийг Ард Аппад нэвтрүүлсэн ба сар бүр 1,000 гаруй харилцагчид үнэт цаасны хуримтлал үүсгэж байна.
- Банк, санхүү, медиа, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг 3 компанид нийт 62 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх хаалттай бондын зөвшөөрлийг амжилттай авсан байна.
- Биржийн бус зах зээл дээр нийт 4 хаалттай бондын материал дээр ажиллаж, нийт 28.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг босголоо.



Нийт хөрөнгө

11.5

▲ 39.9%

Нийт эздийн өмч

8.1

▲ 39.2%

Нийт орлого

2.7

▲ 65.0%

Цэвэр ашиг

(0.8)

▼ 68.0%

Хэмжих нэгж: тэрбум.төгрөг
CAGR: 2020 vs 2022

Крипто

Крипто Үндэстэн ХК

- ▲ Монголын Хөрөнгийн Бирж дээр нэрээ Крипто Үндэстэн ХК болгож, тикерээ CNF болгож өөрчилсөн, II-р ангилал руу дэвшсэн.
- ▲ Ард Бит ХХК болон Ард Венчурс ХХК-г нэгтгэж Крипто болон Блокчэйн кластер үүсгэв.

Ард Бит

- ▲ Шинээр Ардын Эрх (RDX) урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлж Ард Апп дээрх бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийн хэрэглээг амжилттай идэвхижүүлэв.
- ▲ АрдКойн олборлолт буюу Ард Апп ашиглан 524 мянган гүйлгээгээр 76 сая АрдКойныг урамшууллаар харилцагчдад олгов
- ▲ Анх удаа шатаалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн нийт 258.3 сая ширхэг АрдКойныг шатаав.
- ▲ Монголын Хөрөнгийн зах зээлд шинээр Forward хэлцэлийг ажилттай нэвтрүүлэв.

idax exchange

- ▲ Санхүүгийн Зохицуулах Хороонд албан ёсоор Виртуал Хөрөнгийн Үйчилгээ үзүүлэгчээр бүргүүлэв
- ▲ 158,000 гаруй хэрэглэгчтэй болсоноос 55,000 гаруй гадаад харилцагч амжилттай бүртгэв
- ▲ 140 гаруй арилжааны хослол нэмэгдэж, Монголд анх удаа 60 гаруй хослолтой Futures арилжаа, Margin болон ETF арилжааг амжилттай нэвтрүүлэв.
- ▲ ISO/IEC 27001 олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлсэн



ARDMONEY

www.ardmoney.com

Онцлох үйл явдал

ArdMoney

АММ ажиллагаатай төвлөрсөн бус крипто бирж, стейкинг ухаалаг гэрээ, DAO ухаалаг гэрээ зэрэг хөгжүүлэлтүүдийг хийв.

MONT/ARDM, MONT/USDT, MONT/INC гэсэн хослолуудтай Стейкинг ухаалаг гэрээ нь 2022 оны 10 сард хэрэглээнд нэвтэрч 4 сарын хугацаанд зах зээл дээр эргэлдэж байгаа нийт токены 13 орчим хувийг 122 хэрэглэгч стейкинг санд амжилттай төвлөрүүлсэн.

DAO засаглал 2022 оны 12 сард ухаалаг гэрээний хөгжүүлэлт хийгдэж анхны санал хураалтаа амжилттай хийсэн.

Энэхүү санал хураалтаар ArdMoney брендинг, өнгө төрх шинэчлэх санааг дэвшүүлж, токен эзэмшигчдийн тийм гэсэн саналаар биелэгдэж 2 сарын хугацаанд бид брендингээ шинэчилсэн.

Монгол Дифай

idax бирж дээр MNT хослолуудыг MONT-руу шилжүүлсэн

Ард Аппликэйшн дээр MONT худалдан авах, зарах мөн стейкинг үйлчилгээг нэвтрүүлсэн

Ард Арт NFT платформтой хамтын ажиллагааны гэрээ байгуулж NFT худалдан авах боломжуудыг бүрдүүлсэн

АрдМааний төвлөрсөн бус биржийн хослолууд дээр стэйблкойноор ашиглагдаж эхэлсэн

KryptoMN

Шинээр Media-Tech суурьтайгаар "Хөрөнгө оруулалтын цагаан толгой" уриан дор үйл ажиллагаагаа эргэн идэвхжүүлж Тэнгэр ТВ-д өөрийн нэвтрүүлэг болох Krypto Hour-г тогтмол цацахаас гадна үндсэн мэдээний хэсэгт тогтмол оролцож эхлэв.

idax
www.idax.exchange

CRYPTO
NATION

METAFORCE
www.metaland.mn

ARDCOIN
www.ardcoin.com

MONT
www.stablecoin.mn

KRYPTO.MN
www.krypto.mn

Diverse Solutions

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны 12 сарын 31

Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь тусдаа санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Тусдаа санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.
- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулсан.

"Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн ТУЗ-ийн дарга П.Батбаяр, Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг болон Санхүү эрхэлсэн захирал Б.Золбоо бид энэхүү тайлангийн 13-50 дугаар хуудсанд үзүүлсэн компанийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



Хараат бус аудиторын дүгнэлт

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид Компани гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх тусдаа санхүүгийн байдлын тайлан, тусдаа ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан, тусдаа мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хураангуй санхүүгийн тайлан гэх) 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бүх тодруулгыг иж бүрэн агуулаагүй тул Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр тусдаа санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр тусдаа санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.



Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8	3,916	330,722
Дансны болон бусад авлага	9	21,637,849	23,576,380
Бусад санхүүгийн хөрөнгө	10	366,054	10,369,946
Бараа материал	11	97,615	107,959
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12	4,643,904	3,708,456
Эргэлтийн хөрөнгийн дүн		26,749,338	38,093,463
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	13	418,606	645,221
Биет бус хөрөнгө	14	12,020,050	59,160,237
Ашиглах эрхтэй хөрөнгө	15.1	1,281,761	2,349,551
Урт хугацаат хөрөнгө оруулалт	16	96,138,283	231,730,778
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		109,858,700	293,885,787
Нийт хөрөнгө		136,608,038	331,979,250
Өр төлбөр ба эздийн өмч			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны болон бусад өглөг	17	3,598,232	17,686,461
Богино хугацаат зээл	18	2,578,482	6,182,791
Богино хугацаат хаалттай бондын өр төлбөр	19	2,603,000	3,685,489
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	15.2	865,676	979,547
Урьдчилж орсон орлого	20	9,965,930	11,017,456
Богино хугацаат өр төлбөрийн дүн		19,611,320	39,551,744
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	15.2	608,298	1,473,974
Урт хугацаат зээл	18	6,589,586	6,633,373
Урт хугацаат хаалттай бондын өр төлбөр	19	-	1,583,000
Хойшлогдсон татварын өр	21	6,186,750	24,188,557
Урт хугацаат өр төлбөрийн дүн		13,384,634	33,878,904
Өр төлбөрийн нийт дүн		32,995,954	73,430,648
Эздийн өмч			
Өмч-хувьцаат	22.1	28,614,263	28,614,263
Нэмж төлөгдсөн капитал	22.3	2,927,696	2,927,696
Дахин үнэлгээний нөөц	22.5	52,792,679	214,347,421
Эздийн өмчийн бусад хэсэг		13,799	13,799
Хуримтлагдсан ашиг	22.4	19,263,647	12,645,423
Эздийн өмчийн дүн		103,612,084	258,548,602
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		136,608,038	331,979,250

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний орлого	23.1	2,837,210	2,030,180
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз	23.2	3,657,162	3,356,706
Ногдол ашгийн орлого	23.3	1,012,491	1,004,162
Хөрөнгө оруулалтын багцын хүүгийн орлого	23.4	18,247	1,316,383
Нийт хөрөнгө оруулалтын орлого		7,525,110	7,707,431
Хөрөнгө оруулалтын бус бусад орлого	24	6,250,462	784,268
Борлуулалт, маркетингийн зардал	25	(2,227,526)	(1,095,852)
Ерөнхий ба удирдлагын зардал	26	(5,667,047)	(15,766,063)
Санхүүгийн зардал	27	(3,159,929)	(3,346,137)
Бусад зардал	28	(1,633,147)	(2,349,625)
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		(30,959)	(361)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз		-	(26,955)
Виртуал хөрөнгийн үнэлгээний гарз		(17,653)	
Виртуал хөрөнгийг данснаас хассаны олз		1,251,464	14,351,507
Татвар төлөхийн өмнөх ашиг		2,290,775	258,213
Орлогын татварын өгөөж/(зардал)	29	(180,049)	27,437
Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг		2,110,726	285,650
Зогсоосон үйл ажиллагааны ашиг	30	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг		2,110,726	285,650
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгө оруулалт болон виртуал хөрөнгийн үнэлгээний олз(гарз)	31	(155,722,397)	198,869,019
Бусад дэлгэрэнгүй орлогын дүн		(155,722,397)	198,869,019
Нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)		(153,611,671)	199,154,669
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		0.07	0.01

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	28,590,335	(1,414,706)	-	27,284,096	13,799	1,358,572	55,832,096
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	-	285,650	285,650
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	198,869,019	-	-	198,869,019
Өмчид гарсан өөрчлөлт	23,928	1,414,706	2,927,696	-	-	(23,928)	4,342,402
Дахин үнэлгээний нөөцийн хэрэгжсэн дүн	-	-	-	(11,805,694)	-	11,025,129	(780,565)
2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	28,614,263	-	2,927,696	214,347,421	13,799	12,645,423	258,548,602
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	8,005	8,005
Залруулсан үлдэгдэл	8,614,263	-	2,927,696	214,347,421	13,799	12,653,428	258,556,607
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	2,110,726	2,110,726
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	(155,722,397)	-	-	(155,722,397)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	(1,332,852)	(1,332,852)
Дахин үнэлгээний нөөцийн хэрэгжсэн дүн	-	-	-	(5,832,345)	-	5,832,345	-
2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	28,614,263	-	2,927,696	52,792,679	13,799	19,263,647	103,612,084

Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	3,778,396	2,782,715
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,778,396	2,782,715
Бусад мөнгөн орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн	(8,401,355)	(8,302,909)
Ажиллагчдад төлсөн	(1,129,475)	(1,487,785)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(228,277)	(271,633)
Бараа материал худалдан авахад төлсөн	(7,670)	(117,682)
Ашиглалтын зардалд төлсөн	(82,169)	(52,037)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(165,099)	(135,533)
Хүүний төлбөрт төлсөн	(1,734,366)	(2,730,145)
Татварын байгууллагад төлсөн	(1,016,971)	(1,001,667)
Даатгалын төлбөрт төлсөн	(42,031)	(26,755)
Бусад мөнгөн зарлага	(3,995,297)	(2,479,672)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,622,959)	(5,520,194)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	23,441,530	51,176,390
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	7,518,941	10,800,405
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	20,850,000
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	15,864,339	17,665,239
Хүлээн авсан хүүний орлого	15,948	957,000
Хүлээн авсан ногдол ашиг	42,302	903,746
Мөнгөн зарлагын дүн	(15,535,998)	(49,492,446)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	(601,044)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	(100,000)
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(353,807)	(13,587,474)
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	(15,182,191)	(35,203,928)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,905,532	1,683,944
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	9,805,111	20,768,079
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	9,805,111	20,768,079
Мөнгөн зарлагын дүн	(13,414,490)	(16,702,065)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(11,293,169)	(16,415,124)
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	(979,548)	(137,863)
Төлсөн ногдол ашиг	(1,141,773)	(149,078)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,609,379)	4,066,014
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(326,806)	229,764
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	330,722	100,958
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,916	330,722

Үнэлгээ

(сая төгрөг)	Суурь	2020	%	2021	%	2022	%
Стратегийн хөрөнгө оруулалт		67,449		397,699		91,698	
Ард Даатгал (МХБ: AIC)	MV	13,108	66%	14,970	45%	10,535	45%
Ард Кредит (МХБ: ADB)	MV	14,080	61%	25,009	41%	14,630	41%
Монгол шуудан (МХБ: MNP)	MV	17,689	24%	31,727	24%	16,008	20%
Ард Секюритиз	BV	2,305	100%	15,756	90%	5,644	90%
Ард Менежмент	BV	1,265	100%	6,708	90%	1,870	90%
Ард Актив	BV	99	10%	741	9%	804	10%
Ардын Тэтгэврийн Данс	BV	11,426	100%	33,217	95%	9,510	95%
Ард Лизинг	Common stock	0	100%	5,256	100%	1	100%
ТэнГэр Системс	Common stock	1,154	100%	9,950	100%	1,076	100%
Ард Венчурс	BV	6,324	100%	15,002	100%	0	0%
Ард Пропертиз	BV			34,965	100%	4,788	100%
Ард Бит	BV			84,023	100%	0	0%
DAX	DCF	0	60%	45,000	60%	0	0%
Даац Инвестмэнт (УБҮЦБ-ийн 54%)	Cost			51%		4,096	51%
ТэнгГэрЛиг Медиа Нэгдэл (МХБ: TNGR)	MV			48%		22,737	38%
ГрэйпСити Монгол	Cost			9,000	45%		
МОСТ Финтек	Cost			4,500	45%		
Тактикийн хөрөнгө оруулалт		52		15,729		1,069	
Үндэсний Хувьчлалын Сан (МХБ: ХОС)	MV	3	0%	19	0%	26	1%
Хөрөнгө Оруулагч Үндэстэн Сан	MV	28	33%	5,319	28%	589	6%
Бусад санхүүгийн хэрэгслүүд		21		10,391		454	
Бусад		(8,263)		40,137		40,015	
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө		9,407		62,155		13,632	
Бэлэн мөнгө		101		331		4	
Бусад цэвэр хөрөнгө		(17,771)		(22,349)		26,379	
Нийт үнэлгээ		59,239		453,565		132,781	
Нэгж хувьцааны үнэлгээ		2,180		15,851		4,640	

Хувьцааны арилжаа



(тэрбум төгрөг)	Нээлт	Хаалт	Дээд	Доод	Эргэц (%)	Арилжааны дүн	МХБ-н арилжаанд эзлэх %
AARD	9,015	4,880	9,080	3,059	12.5%	23.1	13.8%
AIC	1,296	929	1,349	700	7.3%	2.4	1.4%
ADB	211	129	215	88	4.0%	1.3	0.8%
MNP	1,345	995	1,336	584	0.4%	3.6	2.1%
CNF	164,800	90,720	164,800	40,000	3.6%	1.7	1.0%
TNGR	20,000	16,900	23,100	10,000	0.7%	0.6	0.4%
						32.7	19.5%

Тайлбар толь

ХК	Хувьцаат компани.
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани.
ББСБ	Банк Бус Санхүүгийн Байгууллага.
ХЗХ	Хадгаламж Зээлийн Хоршоо.
ҮЦК	Үнэт Цаасны Компани.
УБУЦБ	Улаанбаатар Үнэт Цаасны Бирж эсвэл Ulaanbaatar Exchange буюу UBХ.
AARD	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа.
AIC	Ард Даатгал ХК-ийн хувьцаа.
ADB	Ард Кредит ХК-ийн хувьцаа.
ХОС	Үндэсний Хувьчлалын сангийн нэгж эрх.
CNF	Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа.
MNP	Монгол шуудан ХК-ийн хувьцаа.
TNGR	ТэнГэрЛиг Медиа Нэгдэл ХК-ийн хувьцаа.
ХОҮС	Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн нэгж эрх.
ARDT	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааны токенжуулсан хэлбэр
CupCake	Худалдан авалтын хариултаа хадгалах үйлчилгээ.
Pick n Pay	Ардын харилцагчид хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүүгүй, шимтгэлгүй хуваан төлөх.
Pension box	Гэр бүлийн гишүүн бүртэйгээ хором, мөч бүрийг "амттай" өнгөрүүлэхэд нь туслах урамшуулалт хөтөлбөр.
Ардын Эрх	Оноо цуглуулан, АрдКойн руу хөрвүүлэн авах урамшуулалт хөтөлбөр.
Ард Апп	Санхүүгийн цогц үйлчилгээг агуулсан, лайф-стайл супер апп.
АрдКидс	Хүүхдийн анхны санхүүгийн апп.
Метаверс орчин	Цахим орчин (виртуал орчин).
API	Application Programming Interface буюу хэрэглээний програмчлалын интерфeйс.
NFT	Non-fungible-token гэдэг нь энгийнээр орлуулшгүй, цор ганц зүйл.
JackPot	Супер хонжвор.
YoY	Year-on-year буюу өмнөх жилийн мөн үеэс хэрхэн өөрчлөгдсөнг илэрхийлнэ.
YTD	Year-to-date буюу оны эхнээс хэрхэн өөрчлөгдсөнг илэрхийлнэ.
CAGR	Compound annual growth rate буюу нийлмэл жилийн дундаж өсөлт.
Sumsub	Automation буюу харилцагчийн хувийн мэдээлэл болон бичиг баримтын мэдээллийг автоматаар таних систем.
KYC	
MoonPay	Олон улсын картаар орлого хийх үйлчилгээ үзүүлдэг олон улсын байгууллага.
AlchemyPay	Олон улсын картаар орлого хийх үйлчилгээ үзүүлдэг олон улсын байгууллага.

